



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 09 дугаар сарын 05

№ 01/71 УАГ-ГАГ/2017/10-7А Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ.

1. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй 29,677,131.00 төгрөгийн орлогод чөлөөлөлт эдэлсэн.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.1.4-д /татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх;/, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д /татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;/, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.10-д /Энэ хуулийн 13.1.15, 13.1.16, 13.1.17-д заасан барааг дамжуулан борлуулж байгаа этгээдэд энэ хуулийн 13.1 дэх хэсэг хамаарахгүй./, 8.2-д /Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах, энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу уг албан татвараас чөлөөлөхдөө "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг баримтална./, 13.7-д /Эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад энэ хуулийн 13.5.10 дахь заалт хамаарахгүй./, 13.12-д /Засгийн газрын бус байгууллагууд Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр санхүүжилт авч төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг бүрэн буюу хэсэгчлэн гүйцэтгэж байгаа үйлчилгээ 13.5.12-т хамаарахгүй./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх 16,198,560.00 төгрөгийн орлогын хуулийн үндэслэлийг буруу сонгосон.

Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-д /татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;/, 18 дугаар зүйлийн 18.1.1-д /татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;/, 8 дугаар зүйлийн 8.2-д /Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах, энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу уг албан татвараас чөлөөлөхдөө "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг баримтална./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал:/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарахгүй орлогод чөлөөлөлт эдэлсэн аж ахуй нэгж, байгууллагын чөлөөлөгдсөн албан татварыг нөхөн төлүүлж, хууль, журамд заасны дагуу арга хэмжээ авах.
2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогын хуулийн үндэслэлийг буруу сонгосон зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар татвар төлөгч нарт зөвлөмж өгөх.
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Татварын хэлтсийн дарга М.Туяацэцэг, татварын улсын ахлах байцаагч П.Цэцэгжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:


АХЛАХ
АУДИТОР



Ч.БЭРХСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА *М.Туяацэцэг* М.ТУЯАЦЭЦЭГ
УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ *П.Цэцэгжаргал* П.ЦЭЦЭГЖАРГАЛ



¹ Албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/